

УМАРД ХИЛИЙН “ХАРУУЛЫН НУТАГ”-ИЙН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ

THE ORIGIN AND THE DEVELOPMENT OF NORTH BORDER “PATROL AREA”

**Л.ОДЗАЯА**

Хууль сахиулахын их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн багш, ахлах дэслэгч

ODZAYA L.

Senior Lieutenant, Lecturer of Social Science faculty at Law and Social Science Institute, Law Enforcement University

Товч агуулга: Энэхүү өгүүлэлдээ “Улсын умард хилийн харуулын нутаг” хэмээх ойлголт хэзээ үүссэн, ямар зориулалттай газар нутаг байсан, хилийн харуулын гүйцэтгэх үүрэг, онцлог тухайлбал 1911-1915 оны хооронд улсын эдийн засаг хийгээд улс төрийн амьдралд ямар үүрэг хүлээж байсан зэргийг өгүүлнэ.

Abstract: In this paper we would like to express when the term “North border land” originated, what was the purpose and intention of this land and what was the special role of border patrols.

We have also attempted to highlight any roles of that place in the country’s economic and political life between 1911-1915.

ҮНДСЭН ХЭСЭГ

Монгол Улсын хойд хилийг 1727 онд Манж Улсын санаачлагаар Хаант Орос Улстай гэрээ байгуулан Ар Монголын нутгийн хойд хэсгээр хил тогтоосонтой холбоотойгоор хилийн харуул байгуулж¹, Халхын умард хилийг чандлан сэргийлэн суух болов. Архивын баримтаас үзвэл, Умард хилийн гэр харуулыг 1730-аад оны эх хүртэл Хиагтын заргач эрхлэн хариуцаж байсан бололтой. Зүй нь, Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамнаас 1727 онд Халхын туслагч жанжин, төрийн жүн ван Данзандоржид илгээсэн албан бичигт өгүүлсэнээр “Өдгөө тулгар, Хиагтын амсарт Хятад нар Орос лугаа нийлж худалдаа хийх бөгөөд шинэ хязгаар тогтоосны тулд Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамны сайд ариухан заргач нэгэн гаргаж улаагаар илгээж захируулж, хэрэг шийтгүүлж хоёр жил нэгэнтээ халуулъя. Энэ гаргах заргачийг харъяат журганаас биеийг

үзүүлэн айлтгатугай. Жич, тэнцүүлж гаргах Халхын Монгол занги, цэргийг хэд суулгаж, яаж явуулах зэргийн явдлыг мөн Түлишэн лугаа тушаан өгч хэлэлцэн айлтгатугай”² хэмээсэн нь энэхүү санааг зарим талаар баталж байна.

Дээрх мэдээнээс үзэхэд, Манж нар Орос Улстай харилцах шинэ хязгаар тогтоосон тул Хиагтын газар худалдаа, хилийн элдэв хэргийг хариуцсан тусгай заргач томилон хоёр жил нэгэнтээ халуулах буюу алба хүлээлгэхээр шийдвэрлэсэн нь тодорхой байна. Түүнчлэн, архивын бичиг дансанд “Харуул хэмээгчид холбогдсон нь маш чухал”³ хэмээн тэмдэглэсэн нь олонтой тохиолдож байгаа нь Манжийн төрөөс Халхын нутгийн умард этгээдэд хилийн харуул байгуулан, харуулд суух өрх, хуяг цэргийг зохион байгуулах ажилд ихээхэн анхаарал тавьж байсныг илтгэнэ. Үүнтэй холбоотойгоор тэдний нутгийг “Харуулын нутаг” хэмээн

¹ Ц.Насанбалжир. Ар Монголоос Манжид залгуулж байсан алба. УБ., 1964. Х.121.

² Ж.Баттөр, Р.Мөнхтулга. Монголын дипломат бичгийн дурсгал. Боть I /Буурын гэрээ/. Эмхтгэл. УБ., 2004. Х.57

³ МУУТА, Х-М1, Д-1, ХН-2603, Нугалбар-1.



нэрлэж байсан юм. Уг ойлголтын талаар түүхч эрдэмтэн Ж.Гэрэлбадрах өөрийн бүтээлдээ “Харуулын нутагт өөр хошууны аливаа ард иргэдэд болон хятадын худалдаачид орох, нутаглахыг хатуу хориглож байсан нь хил орчмын газар нутгийг дэг журамтай, чанд байлгах гэсэн бодлого юм. ...Хилийн харуулыг Монгол Улсын Орос Улстай хил нийлсэн газарт байгуулж, улсын хилийг цагдан шалгаж, сэргийлэн сахиж, хилдээ мал аж ахуй эрхлэн суурьшихыг хориглон хилийн худалдааг хянаж, худалдаа арилжаа хийгчдийн гэрч тэмдгийг чанга хатуу шалгадаг журамтай байв”⁴ гэж бичжээ.

Ийнхүү Ар Монголын хойд хил дээр харуул суулгах болсон шалтгаан нь Монгол Улсыг бусад улсаас тусгаар байлгаж, бусад улсын нөлөөг багасгах нэгэн хөшүүрэг нь умард хилд харуул байгуулах явдал байсан. Улмаар хойд хилийн харуулын алба нь дан ганц биеэр болон өрх гэр, эд хөрөнгийн хамт удаан хугацаагаар томилон суулгаж байсан нь тухайн үеийн нөхцөлд тохирсон зохион байгуулалт байсан гэж судлаачид үздэг.⁵ Ийнхүү хойд хилдээ харуул суулгасан нь өөрсдийн газар нутгийг бататгаж, ноёрхлоо удаан хугацаанд барьж байх явдалтай нягт холбоотой юм.

Энэхүү харуулын албын тухай, “Манжийн үед хамгийн хүнд алба бол өртөө, харуулын алба байсан бөгөөд 1727 оны Буурын гэрээгээр Ар Монголын хойд хил тогтоосноор нийт 82 харуул байгуулж, Орос, Монголын харилцааг хязгаарлах зорилготой байсан бөгөөд хилд суух харуулын зардлыг Монголчууд хариуцаж, 1760 онд 900, 1777 онд 1230 гаруй цэрэг, гэр бүлийн хамт байрлаж байжээ”⁶ гэж үздэг. Харин түүхч, эрдэмтэн Б.Цэдэн-Иш өөрийн бүтээлдээ нийт 76 харуул сууж байсан гэж түүхэн баримтаар баталжээ.⁷

⁴ Ж.Гэрэлбадрах. Монгол нутаг дэвсгэр, хил хязгаарын түүх. УБ., 2006. Х.142.

⁵ Э.Жигмэддорж. Манжийн үеийн Ар Монгол дахь хилийн харуул. УБ., 2006. Х.45.

⁶ Лан Мэй Хуа. Монголын тусгаар тогтнолын төлөө 1911 оны хөдөлгөөн: Нэгдсэн Монгол Улс байгуулах эрмэлзэл. УБ., 2011. Х.82.

⁷ Б.Цэдэн-Иш. Монгол улсын хил хязгаар бүрэлдэн тогтсон түүхээс. УБ., 2003. Х.179-182.

Улмаар хойд хилд сууж байсан харуулууд нь Манжийн ноёрхлын үед хязгаар нутгийн тахилгатай дурсгалт газрууд болон байгалийн баялагтай орд газруудыг хамгаалах, хилийн дагуу шалгалт явуулж, зөрчил гаргагчдыг илрүүлэн баривчилж зохих газарт хуяглан хүргэж, сэжигтэй зүйл, онцлог явдлуудын талаар дээд газарт мэдэгдэх үүрэгтэй байв.

Манж Чин улсын үед байгуулагдсан эдгээр харуулууд нь хойшид Олноо Өргөгдсөн Монгол Улсын үед хэвээр хадгалагдаж, 1911, 1921 оны хувьсгалт үйл явц, цэргийн хүчнийг бэхжүүлэхэд зохих үүрэг гүйцэтгэсэн⁸ хэмээн доктор Э.Жигмэддорж бүтээлдээ дүгнэсэн байна. Улмаар XIX зуун гэхэд Ар Монголын хилийн харуулын зохион байгуулалт нь нэгэнт бэхжин өөрийн өвөрмөц дүр төрхөө олж, Манжийн нөлөө буурч эхлэх үеэс Монгол, Орос хоёр улсын харилцаа өргөжиж эхэлсэн байна. Ийнхүү Олноо Өргөгдсөн Монгол Улсын үед улсын хил хязгаарын хамгаалалт нь урьдах Манжийн үеийнхээс нилээд өөрчлөгдсөн. Учир нь Манж Чин Улс 1911 онд мөхөж, Монголчууд өөрсдийн тулгар төрөө дахин сэргээн тогтоож, хойд хилээ хамгаалахдаа өрхийн харуулуудын тоог цөөрүүлжээ. Үүний шалтгаан нь Олноо Өргөгдсөн Монгол Улс нь Хаант Орос улстай 1912 онд найрамдлын гэрээ байгуулж, улсын хилийг улс төр, дипломатын аргаар хамгаалах болсноор өрхийн гэр болон суман харуулуудыг өөрчлөн, улсын хилийг өрхийн харуулаар хамгаалуулж, харуулын тоог цөөтгөх бодлого баримтлав.

Түүнчлэн, хойд хилийн харуулыг бэхжүүлэхэд түүний удирдлага, зохион байгуулалт нь Халхын дөрвөн аймгийн чуулганы газраас томилогдож, аймгийн жанжинд захирагддаг байв. Тухайлбал: Засагт хан аймгаас 7, Сайн ноён хан аймгаас 12, Түшээт хан аймгаас 14 харуул, Сэцэн хан 14, Солон барга 12, нийт Хиагтын зүүн, баруун этгээдэд 59 гэр харуул байгуулж, тэдгээрийг өрхийн

⁸ Э.Жигмэддорж. Манжийн үеийн ар Монгол дахь хилийн харуул. УБ., 2006. Х.67.



харуулаар сахин хамгаалуулжээ. Хилийн шугам дээр байгаа овоо тэмдгийг “хязгаарын овоо” гэдэг бөгөөд хилийн харуулын хооронд нэг овоо босгож түүн дээрээ хоёр харуулын манаанууд тогтмол хугацаанд уулзаж эв модоо нийлүүлэн шалгаж, бичиг мэдээг солилцдог байсан бөгөөд ийм төрлийн манааг хайч манаа, харин овоог нь “хайч овоо” гэдэг байжээ.

Олноо Өргөгдсөн Монгол Улсын үед “Буурын гэрээ”-ээр тогтоосон уламжлалт хойд хил хэвээр байсан хэдий ч хилийн харуулын нутгаар Орос, Буриад иргэд зөвшөөрөлгүй, өөрдсийн газар мэт дураар нутаглаж байсныг баримтаас харвал, “1916 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн Гадаад Хэргийг Бүгд Эрхлэн Шийтгэгч Яамны бичигт, Манай яамнаас харьяат харуулын нутагт дураар оршин сууж буй хэмээх Орос, Буриад нарыг нэн даруй уул нутагт буцаалгах учир, Хиагтын сайдад явуулсныг цөм данснаа тэмдэглэжээ. Түшээт хан аймгийн харуулыг товчлон захирах түшмэл Жамбалаас харуулын нутаг “Бага булаг” хэмээх газар ноднин жил 6 сарын хугацааны тэмдэгт бичигтэй хэмээх Орос нутгаас байшин авчирч байгуулаад худалдаа хийж бүхий Орос, Хасаг нарын авчирсан бараа юмнаас гааль хураах хэмээвээс түүний үг, Нийслэл хүрээний гаалийн яамнаа гааль хураалгасан тул дахин давхарлан хураалгахгүй хэмээсэн зэрэг учрыг гаргаж өргөсөн тухайд энэ хоёр харуулын нутагт оршин суугч нарыг Хиагтын дэд консулд тодорхойлон хэлж одоо манай сайдын газраас түшмэлийг томилон мордуулж хөөн зайлуулах зэргээр гүйцэтгэн шийтгэнэ үү”⁹ гэсэн өргөн бичиг илгээжээ.

Дээрх нугалбарын мэдээг шинжин үзвэл, хилийн харуулын нутагт суугаа харуулын албан тушаалтан нар хил орчмын газар нутгийг хамгаалахаас гадна тэнд түр суурьшсан иргэдээс түрээс хурааж, улсын санд нийлүүлдэг байсан нь харагдаж байна. Энэхүү үйл явдлыг гэрчлэх өөр нэгэн баримтанд, “1914 оны 9 дүгээр сарын 3-нд Хиагтын зүүн

харуулыг захирах дарга гүн Сумъяагаас харьяат харуулуудын хадлан зэргээс хураасан 9 хувийн цаас 2679 мөнгийг хүргүүлэв хэмээн мэдүүлсэн хэрэгт, Зарлигаар тохоон тавьсан Хиагтын зүүн этгээд 28 харуулыг захирах дарга улсын түшээ гүн Сумъяагийн бичигт, эдүгээ Хиагтын зүүн этгээд олон харуулаас энэ жилийн хадлан өвс, малын бэлчээрийн түрээс зэрэгт хураасан цулгуу цаас 2679 мөнгөний дотроос 10 хувийн нэгэн хувийг шимтгэлд 297 цаас 75 мөнгийг суутган үлдсэнийг эдүгээ Сангийн яамнаа хүргүүлэн хураалгаваас зохих, 9 хувийн цаасыг 2679 мөнгө тушаасныг дагаж харуулын хэргийг хавсран шийтгэлцэх ба товчлон захирах түшмэл Жамбалд тушааж авхуулан өргөн хүргүүлсэн явдлыг олдвоос дээд сайдууд танаа өргөн мэдүүлэв”¹⁰ хэмээн дурджээ. Эдгээр нь Олноо Өргөгдсөн Монгол Улсын үед хилийн харуулыг захирах дарга нар харуулын нутгийг гадаадын иргэдэд түрээсэлж, түүнээс олсон орлогыг харуулыг захирах албан тушаалтан тус түрээсийг Сангийн яаманд нийлүүлж, ийнхүү улсын санд нийлүүлсэн мөнгөө баталгаажуулахын тулд дээд албан тушаалтанд албан бичгээр давхар мэдэгддэг журамтай байсан гэж үзэж болох юм.

Тэгвэл хилийн харуулын нутагт оршин суух түр зөвшөөрлийг хэн өгч байсан бэ? Үүнийг тодруулахын тулд дараах баримтад өгүүлэхдээ, “Гадаадын яамнаа илгээсэн 1913 оны 6-р сард өдрийн албан захидалд, “Буур” зэрэг харуулын захирал залан Базарт тушаан өргөн илгээв. Эдүгээ харьяат аймгийн буур зэрэг 13 харуулыг захирах залан Базараас өргөн мэдүүлсэн бичигт, Эдүгээ Чагтай харуулын цагдаа, хүнд Жамсран нараас мэдүүлсэн бичиг мэдүүлэх учир. Манай Чагтай харуулын нутагт Хиагтын зах комиссарын яамны газраас тэмдэгт бичигтэй буриад Дэндэв, Цэдэнбуу, Аюушжав, Цэрэндорж, орос 8 хүн нарын зэрэг олон хүмүүс өрх хөрөнгөөр нүүн ирж, нутаглан мал адгуулмой хэмээн ирэхэд цагдаа Жамсран бид нар урьханаар хориглон нутаглуулахгүй

⁹ МУУТА, А-3, Х-1, ХН-845, Нугалбар-2.

¹⁰ МУУТА, А-4, Х-1, ХН-237, Нугалбар-1.



учрыг хэлвээс тэдгээр Орос, Буриад бид нар харьяат яамнаас тэмдэг бичигтэй 1 жилийн хугацаагаар үхэр мал хариулахаар найрамдлын ёсоор яваа хэмээн хэлэлцээд огт хэрэгсэхгүй нутаглан малуудыг хариулан бүхий тул уг авч яваа тэмдэг бичгүүдийг хуулан авч ийнхүү учрыг гаргаж харуулыг захирах залан Базар танаа өрнө мэдүүлээд толилон тогтоож заан тушаахыг эрсүгэй хэмээн мэдүүлсэн зэрэг учрыг гаргаж эдгээр Орос, Буриад нарыг нутаглуулан суулгаж болох, үл болохыг толилон тогтоож заан тушаахыг эрэхээс гадна уг хуулан авч хүргүүлэн ирсэн тэмдэг бичиг 5-ыг толилоход бэлтгэл болгон өргөн мэдүүлсэн явдлыг хамтаар гаргасугай хэмээн уламжлан өргөн мэдүүлэв”¹¹ гэжээ.

Мөн тэдний хуулсан зам явах тэмдэгт бичиг тэмдэглэхдээ, “Зам явах тэмдэг бичиг. Их Орос Улсын Хиагтын зүүн захын комиссарын газраас энэ бичигт албаны тамга дарж олгосны учир. Эдүгээ манай улсын харьяат буриад Дэндэв түүнийг дагаж яваа 5 хүний хамт захаас өмнө нэгэн зуун модны доторх Монгол газар “Чагтай” хэмээх харуулд өөрийн үхэр мал тэжээхээр 1 жилийн хугацаагаар одох тул Их Монгол Улсын аливаа зам тохиолдох газар орны түшмэд ард хоёр айл улсын найрамдлыг бодож, саадгүй өнгөрүүлэхээс гадна сайнаар харгалзсугай үүний тул олгов. 1913 оны март сарын 28-ны өдөр” гэснээс харвал хилийн харуулын нутагт түр нутаглан сууж хадлан бэлтгэх, мал хариулах зөвшөөрлийг Хиагтад суух Оросын хил хязгаарын асуудал эрхэлсэн комиссараас авч, түүнийгээ давхар Монгол Улсын Гадаад Хэргийг Бүгд Эрхлэн Шийтгэгч Явдлын Яамнаа айлтгадаг байсныг гэрчилж буй хэрэг юм.

ДҮГНЭЛТ

“Хилийн харуулын нутаг” хэмээх ойлголт нь 1727 онд Халхын Умард хилийг тогтоосонтой холбоотойгоор бий болсон бөгөөд хилийн харуулын нутаг нь Манж Чин Улсын үед зөвшөөрөлгүй

хүн дураар нэвтрэх, мал өсгөх хориотой онцгой бүс нутаг байжээ. Харин Олноо Өргөгдсөн Монгол Улсын үед хилийн харуулын нутагт хойд талаас Буриад, Орос иргэд түр зөвшөөрөл Оросын консулаас авч түрээслэн суудаг байжээ. Улмаар хилийн харуулыг хариуцсан түшмэд нар хилийн харуулыг удирдахаас гадна хилийн харуулын нутгийг түрээслэн суугаа гадаад иргэдээс түрээс хураан авч, улсын санд нийлүүлдэг байсан нь архивын баримтаар нотлогдож байна. Өөрөөр хэлбэл, Олноо Өргөгдсөн Монгол Улсын үед (1911-1919 он) хойд хилийн харуулын түшмэдийн гүйцэтгэх үүрэг өргөжиж, зөвхөн хил хязгаар нутгийн аюулгүй байдлыг хангаж, улсын хилийг хамгаалах үндсэн үүрэг гүйцэтгэхээс гадна харуулынхны суудаг газар нутгийг гадны иргэдэд түрээслэн түүнээс олсон орлогыг улсын санд нийлүүлэх онцгой үүрэг давхар гүйцэтгэж байсан байна. Харин энэхүү үүргийн талаар улсын хилийн түүхийн судалгааны бүтээлүүдэд одоог хүртэл тусгайлан судлагдаагүй байна.

НОМ ЗҮЙ

Эх сурвалж

1. Монгол Улсын Үндэсний Төв Архив. А-3.Х-1.ХН-845. Нугалбар-2
2. Монгол Улсын Үндэсний Төв Архив. А-4. Х-1. ХН-218. Нугалбар-4
3. Монгол Улсын Үндэсний Төв Архив. А-4, Х-1, ХН-237. Нугалбар-1
- Судалгааны зохиол
1. Ч.Алтангэрэл нар. Монгол улсын хил хамгаалалтын түүх. УБ., 2012.
2. Ж.Гэрэлбадрах. Монгол нутаг дэвсгэр, хил хязгаарын түүх. УБ., 2006.
3. Л.Жамсран. Монголчуудын сэргэн мандалтын эхэн. УБ., 1992.
4. Л.Жамсран. Монголын тусгаар тогтнолын сэргэлт. УБ., 1996.
5. Э.Жигмэддорж. Манжийн үеийн Ар Монгол дахь хилийн харуул. УБ., 2006.
6. С.Ичинноров, Б.Шаравсамбуу. Монгол Улсын гаалийн товч түүх. УБ., 1996.
7. Ц.Насанбалжир. Ар Монголоос Манжид залгуулж байсан алба. УБ.,

¹¹ МУУТА, А-4, Х-1. ХН-218, Нугалбар-4.

1964.

8.Ц.Сономдагва. Монгол Улсын засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт, шинэчлэл. 1998, 2015.

9.Б.Цэдэн-Иш. Монгол улсын хил хязгаар бүрэлдэн тогтсон түүх. УБ., 1997.

10.Ж.Урангуа. XX зууны эхэн үеийн Ар Монгол дахь шинэтгэл. УБ., 1997.

**Уншиж танилцан нийтлэхийг зөвшөөрсөн:
Сэтгүүлийн зөвлөлийн гишүүн, цэргийн ухааны доктор, дэд профессор,
хурандаа В.Өвгөнбүргэд**